

❖ ❖ ❖ ❖ ❖

”Мөнхийн Үнэн болох Тэрээр Алдрын Үүрийн Туяанаас Өөрийн мэлмийг Баха-н хүмүүст чиглүүлж, тэдэнд хандан эдгээр үгсийг айлдааж байна: “Хүмүүний үрсийн сайн сайхан, амгалан тайван байдлыг дэмжихийн тулд өөрсдийгөө дайчлагтун. Газар дэлхийн ард түмэн, улс үндэстнүүдийг соён гэгээрүүлэхийн тулд оюун ухаан, хүсэл зоригоо зориул. Тэгэх ахул дэлхийг хагараан бутраагч зөрчил тэмцэл нь Нэн Агуу Алдар нэрийн хүч чадлаар дэлхийн нүүрнээс арчигдан арилж, бүхий л хүн төрөлхтөн Нэг л Эмх журмыг түшиж, Нэг л Хотын оршин суугчид болно. Зүрх сэтгэлээ гэрэлтүүлэн ариусга. Түүнээ үзэн ядалтын өргөс, хорон муу санааны хир буртагт бүү бузарла. Та нар Нэг л Ертөнцөд оршин амьдарч, нэг л Хүсэл зоригийн хүчээр бүтээгдсэн билээ. Туйлын хайр ивээлийн үзэл санаагаар бүх хүмүүстэй холилдон нийлэгч хүмүүн адистат билээ”

Бахаулла, Бахауллагийн Сургаалын Дээжис. мон. CLVI. x 308

“He Who is the Eternal Truth hath, from the Day Spring of Glory, directed His eyes towards the People of Bahá, and is addressing them in these words: “Address yourselves to the promotion of the well-being and tranquillity of the children of men. Bend your minds and wills to the education of the peoples and kindreds of the earth, that haply the dissensions that divide it may, through the power of the Most Great Name, be blotted out from its face, and all mankind become the upholders of the one Order, and the inhabitants of one City. Illumine and hallow your hearts; let them not be profaned by the thorns of hate or the thistles of malice. Ye dwell in one world, and have been created through the operation of one Will. Blessed is he who mingleth with all men in a spirit of utmost kindliness and love”

Bahá'u'lláh, the Bahá'í Faith, the Gleanings, Chapter CLVI (156)

❖ ❖ ❖ ❖

Аяа хүмүүний үр!

Миний мөнхжил бол миний үр бүтээл мөн, түүнийг Би чамд зориулж бүтээсэн тул өөрийн сүмийг түүгээр хучигтуун. Миний нэг нэгдмэл чанар бол Миний бүтээл, түүнийг чамд зориулан буй болгосон. Түүнийг чи өмсөжс амьдрагтуун. Тэгэх аваас чи үүрдийн үүрд Миний мөнх чанарын илэрхийлэл болж явах болой.

Бахаула, Бахай Шүтлэг, Эрдэнийн нуугдмал үгс, Араб 64

O Son of Man!

My eternity is My creation, I have created it for thee. Make it the garment of thy temple. My unity is My handiwork; I have wrought it for thee; clothe thyself therewith, that thou mayest be to all eternity the revelation of My everlasting being.

Bahá'u'lláh, the Bahá'í Faith, Hidden Words, Arabic 64

❖ ❖ ❖ ❖

“Өрнө, Дорнын ард түмнүүд бид энэхүү агуу зорилгыг биелүүлэхийн тулд өдөр шөнөгүй үнэн сэтгэлээсээ тэмцэж, газар дэлхийн улс үндэстнүүдийн хооронд эв нэгдлийг цогцлоон бий болгох ёстой. Чингэвээс хүн бүрийн зүрх сэтгэл сэргэн булгилж, хүн бүрийн мэлмий өргөн нээгдэж, хамгийн гайхамшигт хүчин бүрдэж, хүн төрөлхтний аз жаргал баттай бий болно... Энэ болбоос газар дэлхийд залрах диваажин болох бөгөөд энэ үед бүхий л хүн төрөлхтөн хамтран Алдрын вант Улсын Эв нэгдлийн асар дор хамтран цуглах болно.”

Бахай Шүтлэг, Абдул Бахагийн айлдварууд, Эв нэгдэл

We all, the Eastern with the Western nations, must strive day and night with heart and soul to achieve this high ideal, to cement the unity between all the nations of the earth. Every heart will then be refreshed, all eyes will be opened, the most wonderful power will be given, the happiness of humanity will be assured.

Bahá'í Faith, Jewels from the words of Abdul'-Bahá, Unity

❖ ❖ ❖ ❖